



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/42

Эмээлтолгой

Г Ой хээрийн түймрээс урьдчилан Г
сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн А/90 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж, гарын авлага, сэрэмжлүүлэг бэлтгэн тарааж, Ойн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулиудыг сурталчилах, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх ажил зохион байгуулахыг Эрэн хайх аврах салбар, багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

2.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, идэвхитэн байгаль хамгаалагч, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллахыг Эрэн хайх аврах салбарын дарга (Д.Даваасүрэн), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Сүхбаатар)-д нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХЖАРГАЛ